



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

Өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусийн
халдварын үед авах арга хэмжээний бэлэн
байдлыг хангах тухай

Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусийн дэд хэвшинжээр үүсгэгдсэн хүний томуугийн өвчлөлийн үед халдвартгүйтгэл, ариутгал хийх журмыг нэгдүгээр, Эмнэлгийн мэргэжилтний иж бүрдэл хамгаалах хувцсыг өмсөх, тайлах журмыг хоёрдугаар, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардагдах багаж, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгслэл, эмийн жагсаалтын гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Отгонбаатар), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ш.Энхбат)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Шувууны томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ”-ний тухай Эрүүл Мэндийн Сайдын 2003 оны 45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Сайд

С. ЛАМБАА

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 сарын 15
өдрийн 362 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусээр үүсгэгдсэн хүний
томуугийн өвчлөлийн үед халдвартгүйтгэл, ариутгал хийх журам

Нэг. Нийтлэг зүйл

Өндөр хоруу чанартай шувууны томуугийн хүний өвчлөлийн тохиолдолд голомтонд байнгын ба эцсийн халдвартгүйтгэл хийх, багаж, аппарат хэрэгслийг халдвартгүйтгэх, ариутгахад энэхүү зааврыг мөрдөнө.

1. Өндөр хоруу чанартай шувууны томуугийн вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн голомтод эцсийн халдвартгүйтгэлийг нийслэл, аймгийн төвд 1-2 цаг, суманд 2-3 цаг, багт 3-4 цагийн дотор хийнэ.

2. Өвчний голомтод халдвартгүйтгэл, ариутгалыг мэргэжлийн ариутгач хамгаалах иж бүрдэл өмсгөлтэй хийнэ.

3. Байнгын халдвартгүйтгэлийг бүх шатны улс, хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн болон нийтлэг үйлчилгээний байгууллагууд, нийтийн тээврийн хэрэгсэл, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгжүүд нь өдөр бүр өөрсдөө, урьдчилан сэргийлэх халдвартгүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

4. Халдвартгүйтгэл, ариутгальд хэрэглэж байгаа бодис нь мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл, дүгнэлттэй, чанарын баталгаатай, хадгалалтын хугацаа хэтрээгүй, хэрэглэх аргачлал нь тодорхой, зөв хадгалсан байна.

5. Халдвартгүйтгэлд хэрэглэгдэх бодисыг найруулахдаа цэвэр саванд 50-60 хэмийн бүлээн усаар найруулна.

6. Халдвартын голомтод халдвартгүйтгэлийг хийхдээ үйлдвэрлэгчээс гаргасан аюулгүй ажиллагааны болон хэрэглэх аргыг дагаж мөрдөнө.

7. Халдвартгүйтгэлийн бодисын нөөц хязгаарлагдмал үед мэргэжлийн байгууллагаас зөвлөмж болгож буй халдвартгүйтгэх бодисыг найруулах арга, технологийг баримтлан зааврын дагуу халдвартгүйтгэлд хэрэглэж болно.

Хоёр. Түгээмэл хэрэглэдэг халдвартгүйтгэлийн бодисуудыг
найруулах, хэрэглэх аргачлал

1. “Хлорамин Б” бодисыг халдвартгүйтгэлд хэрэглэх:

1.1. “Хлорамин Б”-д агуулагдах идэвхтэй хлорын агууламж нь 26 - 28% байна. Идэвхтэй хлор нь 16% хүртэл буурвал ариутгал, халдвартгүйтгэлд хэрэглэхгүй.

1.2. “Хлорамин Б”-ын уусмалыг дараах аргаар бэлдэнэ.

1.2.1. Шахмал “хлорамин Б”-ээр уусмал найруулах

| Бэлтгэх уусмалын концентраци | 1 литр усанд хийх шахмалын тоо |
|------------------------------|--------------------------------|
| 0.5% | 10 |
| 1% | 20 |
| 2% | 40 |
| 3% | 60 |

1.2.2. Нунтаг “хлорамин Б”-ээр уусмал бэлтгэх:

| Бэлтгэх уусмалын концентраци (%) | Шаардагдах хлорамин Б (гр) | |
|----------------------------------|-----------------------------|-----------------|
| | 1 литр уусмалд | 10 литр уусмалд |
| 0.5% | 5 | 50 |
| 1% | 10 | 100 |
| 2% | 20 | 200 |
| 3% | 30 | 300 |
| 5% | 50 | 500 |

2. Жавелионыг халдвартгүйтгэлд хэрэглэх:

2.1. Жавелион нь шахмал хэлбэртэй савлагдсан байх ба гол үйлчилгээ үзүүлэгч бодис нь натрийн давс, дихлорцианурийн хүчил. Шахмал нь усанд сайн уусдаг бөгөөд уусмал нь тунгалаг, бага зэрэг хлорлог үнэртэй байна.

2.2. Жавелионы ажлын уусмалыг дараах хэмжээгээр бэлтгэнэ.

| № | Уусмалд агуулагдаж буй идэвхтэй хлорын хэмжээ | 10 литр усанд орох шахмалын тоо |
|----|---|---------------------------------|
| 1. | 0.015 | 1 |
| 2. | 0.03 | 2 |
| 3. | 0.06 | 4 |
| 4. | 0.1 | 7 |
| 5. | 0.2 | 14 |
| 6. | 0.3 | 20 |

2.3. Жавелионыг паалантай, шилэн эсвэл хуванцар саванд найруулж бэлтгэнэ.

2.4. 1 кг цагаан хэрэглэлийг 4 литр уусмалд ариутгахаар тооцно.

2.5. Тасалгааны агаарт $1m^2$ талбайд 100 мл бодис орохоор тооцож хэрэглэнэ.

2.6. Эмнэлгийн багаж хэрэгслийг халдвартгүйтгэхдээ 0.03% -ийн уусмалд 30 минут байлгах ба өрөө тасалгааны цэвэрлэгээнд 0.03-0.1%-ийн уусмал хэрэглэнэ.

2.7. Жавелионыг 0.5% угаагч нунтагтай хольж хэрэглэж болно.

3. Хлорын шохойг халдвартгүйтгэлд хэрэглэх:

3.1. Хлорын шохойд агуулагдах идэвхтэй хлорын хэмжээ нь 32-35% байна.

3.2. Хлорын шохойн уусмалыг дараах аргаар бэлтгэнэ.

3.2.1. Хлорын шохойн 10-20%-ийн сүүн уусмалыг бэлтгэхдээ 1-2 кг хуурай хлорын шохой хэмжин авч бага зэргийн усыг жигд холимог болтол нь нэмж холиод, дараа нь 10 литр хүртэл ус нэмж, сайтар хольж хутгаад тасалгааны хэмд 24 цаг тавина. Дараа нь тунгалаг уусмалыг болгоомжтой өөр саванд юулж авна. Энэ уусмалыг ажлын уусмал гэх ба халдвартгүйтгэлд тусгайлсан өтгөрүүлэн найруулж хэрэглэнэ.

3.2.2 Хлорын шохойн уусмал бэлтгэх:

| Ажлын уусмалын концентраци (%) | Ажлын уусмал дахь идэвхтэй хлорын хувь (%) | 10 литр ажлын уусмал бэлтгэхэд шаардагдах бодисын хэмжээ | |
|--------------------------------|--|--|------------------------------|
| | | Үндсэн 10%-ийн уусмалаас бэлтгэх (мл) | Хуурай бодисоос бэлтгэх (гр) |
| 0.1 | 0.025 | 100 | 10 |
| 0.2 | 0.05 | 200 | 20 |
| 0.5 | 0.125 | 500 | 50 |
| 1.0 | 0.25 | 1000 | 100 |
| 3.0 | 0.75 | 3000 | 300 |
| 5.0 | 1.25 | 5000 | 500 |

4. Саармаг гипохлорит кальцийг хэрэглэх

4.2. Гипохлорит кальци нь нунтаг, цагаан өнгөтэй, хлорлог үнэртэй, үйлдвэрээс 2 төрлөөр бэлтгэдэг. Үүнд:

| Үндсэн үзүүлэлт | Хэмжээ | |
|--------------------------|-----------------------|-----------------------|
| | Марк А | Марк Б |
| Гадна өнгө хэлбэр | Нунтаг, цайвар шаргал | Нунтаг, цайвар шаргал |
| Идэвхтэй хлорын агууламж | 40-45 | 35-37 |
| Усанд уусахгүй байх хувь | 10 | 14 |

4.2. Усан уусмал нь хлорлог үнэртэй тунгалаг биш, савны ёроолд бага зэрэг тундас үүсгэнэ. Гипохлорит кальцийн уусмалаар амархан зэвэрдэг багаж,

хэрэглэлийг халдвартгүйтгэхгүй. Сав суултыг зөвхөн шингэрүүлсэн уусмалаас халдвартгүйтгэнэ.

4.3. Гипохлорит кальцийн сүүн уусмалыг паалантай хувин, шилэн саванд бэлтгэнэ. Сүүн уусмалаас авч зохих хувь хэмжээгээр шингэрүүлж хэрэглэнэ.

4.4. Гипохлорит кальцийн ажлын уусмалыг дараах аргаар бэлтгэнэ. Үүнд:

| Уусмалын хувь | Идэвхтэй хлорын хувь | Уусмал бэлтгэхэд орох бодис, граммаар | | |
|---------------|----------------------|---------------------------------------|-----------------|--|
| | | 1литр уусмалд | 10 литр уусмалд | |
| 0.1 | 0.04-0.035 | 1 | 10 | |
| 0.15 | 0.06-0.0525 | 1.5 | 15 | |
| 0.5 | 0.2-0.175 | 5 | 50 | |
| 1.0 | 0.4-0.35 | 10 | 100 | |
| 1.5 | 0.6-0.525 | 15 | 150 | |
| 2.5 | 1.0-0.875 | 25 | 250 | |
| 3.5 | 1.4-1.225 | 35 | 350 | |

5. ХЛОРСЕПТ-17 бодисыг хэрэглэх:

5.1 Дихлоризоцианурын хүчлийн натрийн давс бөгөөд шахмал хэлбэрээр үйлдвэрлэдэг. Шахмалын дундаж жин нь 3.3 грамм ба 1670 мг, идэвхтэй хлор нь 1000 мг

5.2 Ажлын уусмалыг дараах аргаар бэлтгэнэ. Үүнд:

| Концентраци(%) | Шахмалын тоо (ширхэг) | Усны хэмжээ (литр) |
|----------------|-----------------------|--------------------|
| 0.02 | 1 | 5 |
| 0.03 | 3 | 10 |
| 0.05 | 1 | 2 |
| 0.1 | 1 | 1 |
| 0.2 | 2 | 1 |
| 0.3 | 3 | 1 |
| 1.5 | 15 | 1 |

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 сарын 15
өдрийн баруун тушаалын хоёрдугаар хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний иж бүрдэл хамгаалах
хувцсыг өмсөх, тайлах журам

Эмнэлгийн мэргэжилтэн хамгаалах иж бүрдэл хувцсыг зөв хэрэглэсэн
нөхцөлд халдварт өртөх эрсдлийг бууруулна.

Нэг. Нэг удаагийн хэрэглэгээний хамгаалах иж бүрдэод дараах хэрэгслэл
орно. Үүнд:

- Комбинзон /малгай, угловчтай эсвэл малгайтай/
- Нэг удаагийн халад
- Нүдний шил
- Амны хаалт
- Нэг удаагийн хэрэглэгээний бээлий
- Угловч
- Ахуйн зузаан бээлий
- Хормогч
- Ханцуйвч
- Малгай

Хоёр. Нэг удаагийн хэрэглэгээний хамгаалах иж бүрдлийг дараах
дарааллаар өмсөнө. Үүнд:

1. Мэс заслын өмд, цамц
2. Гутлын углааш юмуу усны гутал
3. Нэг удаагийн халад эсвэл комбинзон /малгай, угловчтай эсвэл
малгайтай/
4. Ус нэвтэрдэггүй хормогч /өвчтөн, шинжилгээ, зөөвөрлөх үед/
5. 1-р бээлий /халадны ханцуйг бээлийний дотор талд орсон байхаар
бээлийгээр даруулж өмсөнө.
6. Амны хаалт /N 95/
7. Малгай
8. Нүдний шил
9. 2-р бээлий

Гурав. Нэг удаагийн хамгаалах иж бүрдлийг дараах дарааллаар тайлна.

1. Бээлийг/ 60%-ийн этилийн спиртээр арчина/, гутлыг /1%-ийн
гипохлорид натри эсвэл 5%-ийн хлораминаар/ халдвартгүйтгэнэ.
2. Эмнэлгийн ажилтны нүдний шилийг туслах ажилтан авна.
3. Туслах ажилтан-1 дэх хос бээлийгээ тайлна /хамгийн гадна
тالын/
4. Эмнэлгийн ажилтны комбинзоны цахилгааныг туслах ажилтан
тайлна.
5. Туслах ажилтан -2 дах хос бээлийгээ тайлна.
6. Комбинзоныг дотроос нь гадагшлах хөдөлгөөнөөр тайлна.
7. Амны хаалтыг (ажилтан өөрөө) тайлна.

8. Эмнэлгийн ажилтан 1 дэх хос бээлийгээ тайлна.
9. Эмнэлгийн ажилтан гутлын углаашаа өөрөө тайлна.
10. Ажилтан 2 дах хос бээлийгээ тайлна.
11. Туслах ажилтан хувцсыг хог хаягдлын сав, уутанд хийнэ. Хог хаягдлын сав уутны гадна талыг бохирдуулахгүй байна.
12. Орчинд халдвартгүйтгэл хийнэ.
13. Туслах ажилтан нүдний шилээ тайлна.
14. Туслах ажилтан 3 дах хос бээлийгээ тайлна.
15. Туслах ажилтан комбинзоны цахилгааныг өөрөө тайлна.
16. Туслах ажилтан комбинзоныг дотроос гадна тал руу нь чиглүүлэн тайлна.
17. Гутлаа/ углааш/ тайлаад 4 дэх бээлийг тайлна.

Дөрөв. Давтан хэрэглэгдэх даавуун өмсгөлд уушгины хэлбэрийн тарваган тахлын 1 дүгээр зэрэглэлийн өмсгөл орно. Үүнд:

- Мэс заслын өмд, пижам
- Оймс
- Усны гутал
- Шаардлагатай тохиолдолд чагнуур
- Нэг удаагийн бээлий
- Гурвалжин алчуур
- Хойшоо харсан халад
- Амны хаалт
- Нүдний шил
- Нэг удаагийн бээлий
- Гарын алчуур

4.1. Өмсгөлийг 3-4 цаг ажиллахад тохиромжтой байхаар тооцон ажлын аюулгүй байдлыг хангаж 2.1 дүгээрт заасан дарааллаар өмсөнө.

4.2. Халадны захны бүч, бүсийг зүүн урд талдаа, 2 ханцуйны бүчийг шууны гадна хэсэгт тус тус хөвөрхөн уяна.

4.3. Амны хаалтыг ам, хамраа бүрэн хаахын тулд дээд ирмэгийг нүдний доод зовхины доогуур байрлуулан бүчийг хүзүүний ар хэсэгт, доод ирмэгийг эрүүний доогуур оруулан бүчийг дээш татаж дагсан дээрээ хөвөрхөн уяна. Хамрын 2 талд агаар гарахаас сэргийлэн бөөрөнхий хөвөн хавчуулна.

4.4. Нүдний хамгаалах шил зүүхийн өмнө хүрээндээ сайн бэхлэгдсэн эсэхийг шалгаж шилний дотор талын ирмэгээр үл цантуулагч тусгай харандаа эсвэл хатсан савангаар зурж шил рүү зөөлөн даавуугаар жигд арчина.

4.5. Резинэн бээлийг өмсөхийн өмнө бүтэн эсэхийг агаар оруулж шалгана.

4.6. Гарын алчуурыг халадны бүсний баруун урд талд 2/3-ыг нь гадна талд унжиж байхаар тооцож хавчуулна.

4.7. Эмгэг судлалын шинжилгээ, угаалга, цэвэрлэгээ, халдвартгүйтгэл, ариутгал, хийх, биеийн шингэнтэй харьцах үед хулдаасан хормогч, ханцуйвч өмсөнө.

4.8.Өмсгөлийг зөөлөн хөдөлгөөнөөр дараах дараалаар тайлна. Үүнд:

1. Бээлийтэй гарыг халдвартгүйтгэх уусмалаар 1-2 минут сайтар угаана.
2. Гарын алчуурын бохир хэсгийг дотогш хумих маягаар сугалж авна.
3. Хулдаасан хормогч ба ханцуйчийг хөвөнд шингээсэн халдвартгүйтгэх уусмалаар арчиж норгоод гадна талыг нь дотогш эвхэж тайлна.
4. Давхар бээлийний гадна талыг нь тайлна.
5. Гуталтай хөлөө халдвартгүйтгэх уусмалтай түмпэн дотор гишгэж, уусмал дотор байгаа хөвөнгөөр түрийнээс нь дотогш тойруулан арчаад уусмалаас хөлөө гаргаж, нөгөө гутлаа дээрх маягаар арчина. Гутал тус бүрт өөр өөр норгосон хөвөн хэрэглэнэ.
6. Арьсны ил хэсэгт хүргэхгүйгээр чагнуурыг авна.
7. Нүдний хамгаалах шилний гадна хүрээнээс хоёр гараараа барьж урагш, дээш, хойш гэсэн дарааллаар авна.
8. Амны хаалтны гадна талыг нүүрэндээ хүргэхгүйгээр тайлна.
9. Халадыг зах, бүсийг хөвөрхөн уясан үзүүрээс нь татаж тайлна. Бээлийний шуумаг хэсгийг урагш эргүүлж арьсанд хургэлгүйгээр тайлна. Халадыг хоёр гараа зөрүүлж мөрний хэсгээс барьж урагш нь эгц татаж биеэс хөндийрүүлэн бохир хэсгийг дотогш хумих маягаар эвхэж авна.
10. Толгойг бага зэрэг бөхийлгэн хошуу алчуурын үзүүрүүдийг толгойн орой дээр авчирч, нөгөө гараараа 3 талыг эвхэж цуглувлан тайлна.
11. Үйлдэл бүрийн дараа бээлийтэй гарыг ариутгана.
12. Резинэн бээлийг тайлж цоорсон эсэхийг гар угаах уусмал дотор хийж шахан шалгана. Хэрвээ цоорсон бол гараа савандаж угаасны дараа халдвартгүйтгэнэ.
13. Хамгаалах хувцсыг тайлсны дараа гараа 70%-ийн этилийн спиртээр арчиж, савантай бүлээн усаар сайн хөөсруулж угаана.

4.9.Бээлийг тайлсаны дараа гарыг нянгийн эсрэг үйлчилгээтэй савангаар сайтар савандаж угаана.

4.10.Хувцсыг 2 давхар уутанд цуглувлан 1-3 хувийн хлорамин, 0,3-0,6 хувийн жавелионы уусмалын аль нэгт хийж 1 цагийн турш халдвартгүйтгэн угааж индүүдсэний дараа автоклавт 1.5 атмосферийн даралт, 126 хэмд 30 минут ариутгана.

4.11.Нүдний шил, чагнуурыг 70 хувийн этилийн спиртэн уусмалд 5 минут дүрэх буюу арчиж ариутгана.

4.12.Хормогч, ханцуйвч зэргийг халдвартгүйтгэлийн уусмалд 15-20 минут дүрэх буюу арчина.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 сарын 15
362 өдрийн тоот тушаалтын гуравдугаар хавсралт

Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд шаардагдах багаж,
тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгслэл, эмийн жагсаалт

Нэг. Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусlamж, үйлчилгээнд
шаардагдах багаж, тоног төхөөрөмж

| Д/д | Багаж тоног төхөөрөмжийн нэр | Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатал | | | | | |
|-----|--|---------------------------------------|----------------|----------------|-------|--------------|--------------|
| | | Анхан шатал | | | Бусад | 2 дахь шатал | 3 дахь шатал |
| Д/д | Багаж тоног төхөөрөмжийн нэр | Сум, сум | Дундын эмнэлэг | Өрхийн эмнэлэг | | | |
| 1 | Амьсгалын аппарат | 1* | - | - | - | 5 | 10 |
| 2 | Хүчилтөрөгч өтгөрүүлэгч | 1-2 | 1 | - | - | 5 | 10 |
| 3 | Отсос | 2 | 1 | 1 | 1 | 5 | 10 |
| 4 | Монитор | 2 | - | - | - | 10 | 15 |
| 5 | Пульсоксиметр | 10 | 5 | 2 | 2 | 10 | 15 |
| 6 | Утлагын аппарат | 1 | 1 | 1 | 1 | 2 | 3 |
| 7 | Амбу | 4 | 2 | 2 | 2 | 5 | 10 |
| 8 | Рентген шинжилгээний аппарат | 1* | - | - | - | 1 | 3 |
| 9 | Халуун хэмжигч | 30 | 10 | 5 | 5 | 40 | 60 |
| 10 | ЭХО / суурин, зөөврийн / | 1 | - | 1* | 1* | 3 | 10 |
| 11 | Цусны хийн анализатор | 1* | - | - | - | - | 1 |
| 12 | Инфузомат /шингэн тохируулан хийх аппарат/ | 2 | - | - | - | 5 | 15 |
| 13 | Тариурын шахуурга | 2 | 1 | - | - | 5 | 15 |
| 14 | Төвлөрсөн хийн хангамжийн систем | - | - | - | - | - | 1 |
| 15 | Цахилгааны нөөц үүсгэвэр | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |

Тайлбар: *Сум дундын эмнэлэгт

Хоёр. Хамгаалах хувцас, хэрэгсэл

2.1. Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд:

| Д/д | Хэрэгслийн нэр | Хэмжих нэгж | Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлал | | | | |
|---|----------------|----------------|--|-----|-------|---------------|---------------|
| | | | Анхан шатлал | | Бусад | 2 дахь шатлал | 3 дахь шатлал |
| Сум | Дундны эмнэлэг | Өрхийн эмнэлэг | | | | | |
| 1. Амны хаалт (N95) | Ш | 100 | 30 | 20 | 500 | 1000 | |
| 2. Амны хаалт (3M) | Ш | 200 | 100 | 30 | 500 | 1000 | |
| 3. Нүүрний хаалттай малгай | Ш | 15 | 10 | 5 | 25 | 50 | |
| 4. Нэг удаагийн халад | Ш | 300 | 100 | 50 | 1000 | 2000 | |
| 5. Малгайтай комбинезон (T4 ₅) | Ш | 50 | 20 | 10 | 250 | 500 | |
| 6. Малгайтай комбинезон (Tyvek) | Ш | 50 | 20 | 10 | 1000 | 2000 | |
| 7. Ажлын хувцас /эмнэлгийн малгай/ халад, | Иж бүрдэл | 30 | 20 | 10 | 50 | 150 | |
| 8. Нүдний шил (GSC загвар A5103 US) | Ш | 15 | 10 | 5 | 50 | 100 | |
| 9. Нүдний шил (UVEX) | Ш | 15 | 10 | 5 | 50 | 100 | |
| 10. Нүүрийг хагас бүрсэн амны хаалт (MP 6200) | Ш | 20 | 10 | 5 | 50 | 100 | |
| 11. Ус нэвтэрдэггүй хормогч | Ш | 10 | 5 | 3 | 20 | 50 | |
| 12. Гутлын угловч | Ш | 300 | 300 | 100 | 1000 | 2000 | |
| 13. Малгай | Ш | 300 | 300 | 100 | 1000 | 2000 | |
| 14. Цогцос хадгалах уут | Ш | 2 | 2 | - | 2 | 3 | |
| 15. Зөөврийн хуванцар сав | Ш | 2 | 2 | 1 | 2 | 4 | |
| 16. Бээлий (ахуйн зориулалтын зузаан) | ХОС | 100 | 50 | 20 | 150 | 300 | |
| 17. Бээлий (нэг удаагийн) | Хайрцаг | 10 | 5 | 2 | 15 | 20 | |
| 18. Усны гутал | ХОС | 10 | 5 | 5 | 15 | 25 | |

2.2. Шувууны аж ахуйд ажиллагсдад:

| д/д | Хэрэгслийн нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|-----|---|-------------|------------|
| 1. | Амны хаалт (N95) | Ш | 100 |
| 2. | Амны хаалт (3M) | Ш | 100 |
| 3. | Нүүрний хаалттай малгай | Ш | 10 |
| 4. | Нэг удаагийн халад | Ш | 200 |
| 5. | Малгайтай комбинезон (T4 ₅) | Ш | 200 |

| | | | |
|-----|---|-----------|----------|
| 6. | Малгайтай комбинезон (Tyvek) | ш | 200 |
| 7. | Ажлын хувцас | Иж бүрдэл | 100 |
| 8. | Нүдний шил (GSC model A5103 US) | ш | 10 |
| 9. | Нүдний шил (UVEX) | ш | 10 |
| 10. | Нүүрийг хагас бүрсэн амны хаалт (MP 6200) | ш | 50 |
| 11. | Үс нэвтэрдэггүй хормогч | ш | 20 |
| 12. | Усны гутал | ш | 100 |
| 13. | Малгай | ш | 100 |
| 14. | Бээлий (ахуйн зориулалтын зузаан) | ш | 100 |
| 15. | Усны гутал | хос | 20 |
| 16. | Үхсэн шувуу, сэг, зэм зэргийг хийх уут | ш | 100-500* |

Тайлбар: * Тухайн аж ахуйн шувууны тоо, учирч болох эрсдлээс хамаарч тооцно.

Гурав. Эмийн нөөцийн жагсаалт

| Эмийн нэр | Нэг бүрийн тун | Хэмжих нэгж | Эрүүл мэндийн байгууллагууд | | | | |
|---------------------------|-----------------|-------------|-----------------------------|--------|-------|--------------|-------|
| | | | Анхан шатны | | | 2 дахь шатны | |
| | | | Сум, сум дундын | Өрхийн | Бусад | | |
| 1 Рибавирин | 100 мг | Шахмал | 3000 | 1000 | 1000 | 8000 | 15000 |
| 2 Ацикловир | 0.02 | | 50 | 40 | 30 | 80 | 100 |
| 3 Левамизол | 100 мг | | 300 | 200 | 150 | 600 | 1000 |
| Тамифлю | 75 мг | | 2000 | 1000 | 2000 | 8000 | 15000 |
| 5 Седальгин | 0.5 | | 100 | 100 | 80 | 200 | 400 |
| 6 Гентамицин | 2 мл | Ампул | 1000 | 900 | 500 | 2 000 | 4000 |
| 7 Диклофенак | 75 мг/мл | | 50 | 50 | 30 | 100 | 200 |
| 8 Нош-па | 40 мг 2 мл | | 100 | 100 | 50 | 300 | 500 |
| 9 Преднизолон | 40 мг | | 500 | 100 | 500 | 8000 | 10000 |
| 10 Эуфиллин | 2.4% 10.0 | | 1000 | 500 | 1000 | 8000 | 10000 |
| 11 Цефазолин | 1 гр | Флакон | 1000 | 500 | 500 | 3000 | 5000 |
| 12 Тималин | 5 мг | | 300 | 200 | 100 | 600 | 1000 |
| 13 Цефатаксим | 1 гр | | 500 | 200 | 500 | 1 500 | 2000 |
| 14 Натри хлорид | 0.9% 400мл | | 200 | 200 | 100 | 350 | 500 |
| 15 Натри хлорид | 0.9% 200 мл | | 200 | 200 | 100 | 350 | 500 |
| 16 Маннитол | 10% 200 мл | Хайрцааг | 70 | 50 | 30 | 100 | 120 |
| 17 Ибупрофен | 0.4 №100 | | 10 | 30 | 15 | 50 | 100 |
| 18 Церебролизин | 1.0 №10 | | 50 | 5 | 15 | 80 | 100 |
| 19 Панангин | 10 мл №5 | | 15 | 15 | 10 | 20 | 30 |
| 20 Пирацетам | 20%-5мл №10 | | 50 | 40 | 20 | 100 | 200 |
| 21 Дигоксин | 0.025% 1 мл №10 | Тюб | 8 | 8 | 5 | 8 | 10 |
| 22 Циклоферон | 12.5% №5 | | 50 | 40 | 20 | 100 | 200 |
| 23 Церукал | 2 мл №10 | | 20 | 20 | 10 | 30 | 50 |
| 24 Алоз | 1 мл №10 | | 100 | 80 | 40 | 150 | 300 |
| 25 Инозин | 2% 5 мл №10 | | 80 | 80 | 50 | 100 | 150 |
| 26 Диклофенак | 50 мг №100 | | 10 | 20 | 5 | 80 | 100 |
| 27 Дексаметазон | 4 мг 1 мл | | 3000 | 1 000 | 2000 | 10000 | 20000 |
| 28 Кокарбоксилаз | 5 мл №5 | | 250 | 250 | 100 | 420 | 720 |
| 29 Оксолины тосон түрхлэг | 10 гр | | 500 | 400 | 500 | 1000 | 2000 |